



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

**Иргэний нисэхийн салбарын удирдах
ажилтны зөвлөгөөн зохион
байгуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Иргэний нисэхийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2018 оны 03 дугаар сард зохион байгуулсугай.

2. Иргэний нисэхийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн

дарга: С.Манлай

Дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга

Нарийн бичгийн

дарга: Д.Ариунтуяа

Захиргаа, удирдлагын газрын захиргаа, хүний нөөцийн менежер

Гишүүд: Т.Батжаргал

Захиргаа, удирдлагын газрын дарга

Г.Батбаяр

Агаарын харилцаа, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагааны зохицуулалтын хэлтсийн дарга

Д.Эрдэнэбаатар

Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга

Ё.Эрдэнэбат

Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга

Ч.Нямсүрэн

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

П.Мөнхжаргал	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны дарга
Д.Баяртогтох	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны дарга
П.Ариунгэрэл	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны дарга
Г.Түвшинбаяр	Нислэгийн журам, боловсруулалтын албаны дарга
С.Нацагдорж	Газрын тусгай үйлчилгээний албаны дарга
Д.Мөнхбаатар	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын захирал
Д.Мөнхцог	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны дарга
Б.Лхагвасүрэн	Захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

Агаарын тээвэрлэгчдээс:

Б.Дөлгөөн	“МИАТ” ХК-ийн Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /тохиролцсоноор/
Б.Мөнхтамир	“МИАТ” ХК-ийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга /тохиролцсоноор/
Д.Тэмүүлэн	“Хүннү эйр” ХХК-ийн Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн
Э.Сайнжаргал	“Аэро Монголиа” ХХК-ийн Захиргаа, хүний нөөцийн мэргэжилтэн


Төрийн бус байгууллагуудас:

Л.Нямбаяр	Агаарын тээвэрлэгчдийн холбооны тэргүүн
З.Энхбаяр	Монголын нисгэгчдийн холбооны тэргүүн
Ё.Батнасан	Монголын нислэгийн удирдагчдын холбооны тэргүүн
Д.Эрдэнэбаатар	Монголын нисэхийн мэдээллийн үйлчилгээний ажилтнуудын холбооны тэргүүн

3. Иргэний нисэхийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллага, агаарын тээвэрлэгч компани, салбарын төрийн бус байгууллагын удирдлагуудыг идэвхтэй хамруулах, зөвлөгөөнийг чанартай, үр дүнтэй зохион байгуулах, зөвлөгөөний материалыг эмхэтгэж сурталчлах арга хэмжээ авах, бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн дотор гаргаж батлуулахыг Ажлын хэсэг /С.Манлай/-т даалгасугай.

4. Зөвлөгөөний үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг батлагдсан төсвийн дагуу гарган зарцуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



2018.02.28

Л.БЯМБАСҮРЭН